



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 214

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 8,169,229.00 (найман сая нэг зуун жаран есөн мянга хоёр зуун хорин ес) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа 3.Азатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 2-р дугаар сарын 25-өдрийн  
2-р дугаар тогтоолын хавсралт



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОНЦГОЙ ГАЗРЫН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
АКТАЛЖ ДАНСААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д      | Хөрөнгийн нэр         | Ашиглалтад орсон он | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл                  |
|----------|-----------------------|---------------------|------------|-------------------------|-----------------------------------------------------------|
| 1        | Пиат /түргэний машин/ | 1992                | 1          | 7,480,000.00            | 7,480,000.00                                              |
| 2        | Хаман боогч           | 2008                | 1          | 689,229.00              | 689,229.00                                                |
| Нийт дүн |                       |                     |            |                         | 8,169,229.00                                              |
|          |                       |                     |            |                         | (найман сая нэг зуун жаран есөн мянга хоёр зуун хорин ес) |